



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 02

Номгон

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг
дээшлүүлж, гэмт хэрэг зөрчлөөс
урьдчилан сэргийлэх тухай

Баянхонгор аймгийн хэмжээнд 2025 онд 706 гэмт хэрэг, 32305 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оноос гэмт хэрэг 129 нэгжээр, зөрчил 1537 нэгжээр тус тус өссөн бөгөөд 25 албан хаагч гэмт хэрэгт холбогдож 2 нэгжээр, 292 албан хаагч зөрчилд холбогдож 14 нэгжээр, 127 малчин гэмт хэрэгт холбогдож 38 нэгжээр, 204 ажилгүй иргэн гэмт хэрэг холбогдож 46 нэгжээр, Авлигын хэрэг 2025 онд 39 бүртгэгдэж 6 нэгжээр тус тус өссөн байна.

Мөн Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 197 бүртгэгдэж 48 нэгжээр, хулгайлах гэмт хэрэг 97 бүртгэгдэж 38 нэгжээр, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 119 бүртгэгдэж 42 нэгжээр, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 14 бүртгэгдэж 6 нэгжээр согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 226 бүртгэгдэж 49 нэгжээр тус тус өсжээ.

Дээрх гэмт хэргийн нөхцөл байдлаас дүгнэхэд иргэд, төрийн албан хаагчийн эрх зүйн мэдлэг дутмагаас шалтгаалж, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, хохирогч болох зэрэг сөрөг үр дагаврууд гарч байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т "... бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бусад байгууллага хууль тогтоомжийг өөрийн бүрэн эрх, чиг үүргийн дагуу харьяалах салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна" гэж заасны дагуу иргэд, төрийн албан хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр бодитой үр дүнтэй сургалт нөлөөлөл, соён гэгээрүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажиллах шаардлагатай байгааг тэмдэглээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гэмт хэрэг, зөрчлөөс

: 642402040

урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн сум, байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт ДААЛГАХ НЬ:

1. Ёс зүйн зөрчил, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

1.1. Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;

1.2. Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;

1.3. Төрийн байгууллагын эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмж болон албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байж, албаны хэрэгцээнд ашиглаж байгаа "хөх" өнгийн дэвсгэр бүхий улсын дугаартай автотээврийн хэрэгслийг хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх;

1.4. Төрийн байгууллагуудын албан хаагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх чиглэлээр сар бүр мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж тодорхой үр дүн гаргасан байх;

1.5. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг бодитой үр дүнтэй зохион байгуулж, албан хаагч энэ төрлийн болон бусад төрлийн гэмт хэрэг, зөрчилд холбогдоогүй байх чиглэлээр бодлогын арга хэмжээ авах.

1.6. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, ёс зүйг эрхэмлэх чиглэлээр бүх шатны төрийн байгууллагууд өглөө бүр ажлаа эхлэхдээ ёс зүйн хэм хэмжээг сануулах "Цахим хөтөч" ажлыг хэвшүүлэх

1.7. Сум, байгууллагуудын үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйлц явц болон нууцад хамаарахаас бусад мэдээллийг олон нийтэд нээлттэй, ойлгомжтой, хүртээмжтэй хүргэж ажиллах.

2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр

2.1. МУЗГ-ын 2024 оны 86 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, сум, байгууллагад суурилагдсан телехяналтын камерын ашиглалтыг сайжруулах, байнгын ажиллагаатай байх, Теле камерын дэд төвд сум, байгууллагын камерын системийг холбох чиглэлээр бодлогын арга хэмжээ авч ажиллах.

2.2. Сум, байгууллагын гадна гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, сайжруулах.

2.3.Нутаг дэвсгэрийн хэмжээнд зонхилон үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж ажиллах.

2.4.“Аюулгүй гудамж – аюулгүй баг” төсөл арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд санаачлан жишиг болохуйц ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах.

3.Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр

3.1.Салбарын хууль тогтоомжийг чиг үүргийн дагуу харьяалах салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах.

3.2.Иргэдийн хууль зүйн боловсролыг дээшлүүлэх "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг сум, байгууллага бүр 2 удаа зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах.

3.3.Төрийн мэдээлэл сэтгүүлийг захиалж, хууль тогтоомжийн сан бүрдүүлж, Төрийн мэдээлэл сэтгүүлд нийтлэгдсэн хууль тогтоомжид өөрчлөлтийг тухай бүр хийж ажиллах (төрийн мэдээлэл сэтгүүлийг тогтмол захиалах, хууль тогтоомжийн нэгдсэн файльтай болсон байх г.м)

3.4.Төрийн албан хаагчдаас иргэдэд өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээллийг тухай бүр өгч бүртгэл хөтөлж, зөвлөн туслах үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллах.

3.5."Явуулын эрх зүйн тусалцаа" арга хэмжээг сум, байгууллага хамтран алслагдсан баг, отор нүүдлээр яваа малчдад хүргэж ажиллах.

3.6."Дижитал сурталчилгаа" залуучууд болон төрийн албан хаагчдад зориулан авлигын эсрэг болон гэмт хэргээс сэргийлэх богино хэмжээний (reel, tiktok хэлбэрийн) контентуудыг орон нутгийн телевиз, сошиал сувгуудаар сурталчилж ажиллах.

4.Албан даалгаврын хүрээнд сум, байгууллага бүр холбогдох албан хаагчийг үүрэгжүүлж, хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, улирал бүр тайлагнаж ажиллахыг сум, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Д.Сарангарав)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ